



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.12.03

№

10/93

“ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН  
ТҮГЭЭХ” ТӨХК-ИЙ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Ч.БАТТУЯА ТАНАА

ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 18.5 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.8 дугаар зүйлд заасан цаглаварын дагуу энэхүү аудитыг “Б энд С аудит” ХХК гүйцэтгэлээ.

“Город” кассын 2012 оны 7 дугаар сарын 30, 31-ны өдрийн орлогоос касс Ундармаагаас 4.4 сая төгрөг, касс Номингоос 3.7 сая төгрөг, нийт 8.2 сая төгрөгийн авч бүртгэлд тусгаагүй, мөн “Булган” салбарын “тэг” үлдэгдэлтэй мөнгөн хөрөнгийн данснаас “Хүдрэг” ХХК-д 25.0 сая төгрөг, “Чадангууд” ХХК-д 3.5 сая төгрөг, “Хааз сар” ХХК-д 29.0 сая төгрөг, нийт 57.5 сая төгрөгийг тухайн өдрийн орлогыг төв салбарт төвлөрүүлсэн байдлаар хааж, Санхүү-тайлан бүртгэлийн хэлтэсийн дарга, ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан М.Энхтуяа албан тушаалаа урвуулан ашигласан нь НББ-ийн тухай хуулийн 19.1.6-д “Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжинд харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах”, 20.1-д “аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох нь албан тушаалаа урвуулан ашиглах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих...” гэж заасныг үндэслэн **АКТ ТОГТООХ НЬ:**

1. Дээр дурьдсан 65.7 сая төгрөгийн орлогыг холбогдох эзнээр төлүүлж, “ЭБЦТС” ТӨХК-ий Төрийн банкны орлогын 13000002562 дугаар дансанд 2014 оны 3 дугаар сарын 1-ний дотор төвлөрүүлэх,
2. Тогтоосон актын төлбөрийг барагдуулах ажлыг Эдийн засгийн асуудал эрхэлсэн дэд захирал, ерөнхий нягтлан бодогч Х.Жаргаланбаатар, ахлах нягтлан бодогч Л.Оюунчимэг нарт хариуцуулав,
3. Актын биелэлтийг гаргаж, 2014 оны 3 дугаар сарын 15-ны дотор ҮАГ-т ирүүлэх.

ТОГТООСОН:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР

Л.ОДГЭРЭЛ  
“Б ЭНД С АУДИТ” ХХК-ИЙ  
ЗАХИРАЛ

Д.ДАШХОРЛОО

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

ЭБЦТС ТӨХК-ИЙ ЭДИЙН ЗАСГИЙН  
АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Х.ЖАРГАЛАНБААТАР  
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

Л.ОЮУНЧИМЭГ

070320